ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.04.22 № 433

танай ____________-ы № ______________-т

ХЭНТИЙ АЙМГИЙН МӨРӨН
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ц.БАТЦООЖ ТАНАА

Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан, дүгнэлтийг зөвлөмжийн хамт хүргүүлж байна.

Аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 10 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлнэ үү.

Хавсралт 25 хуудас

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

02303041

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: ХЭА-2021/16/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Чингис хот

2022 он


Тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112

Цахим хаяг:

Аудитын менежер: Д.Оюунтуяа

Утас: 99775390

Цахим хаяг:

Аудитор: Х.Еркегүл

Утас: 99040705

Цахим хаяг: erkegulkh@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын гэрчилгээ ..... 3
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
3. Аудитын тайлан ..... 9
3.1. Ерөнхий зүйл ..... 9
3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ..... 9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 9
3.4 Материаллаг байдал ..... 10
3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт ..... 10
3.5.1 Мөнгөн хөрөнгө ..... 10
3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт ..... 11
3.5.3 Авлага ..... 11
3.5.4 Урьдчилгаа ..... 11
3.5.6 Бараа материал ..... 12
3.5.7 Үндсэн хөрөнгө ..... 12
3.5.8 Өр төлбөр ..... 13
3.5.9 Засгийн газрын хувь оролцоо ..... 13
3.5.10 Орлогын данс ..... 13
3.5.11 Зардлын данс ..... 14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 15
3.7 Шилэн дансны мэдээлэл ..... 17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 18
3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 18
3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 18
4. Менежментийн захидал ..... 19
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ..... 20

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЖДБДС | Жижиг дунд бизнесийг дэмжих сан |
| СХС | Сум хөгжүүлэх сан |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.04.22 № 421

танай ______________ -ны № ________________ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ц.БАТЦООЖ ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2020оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | 667,116.4 | 891,428.9 |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 98,840.5 | 207,663.7 |
| **32** | **БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 0.0 | 0.0 |
| **33** | **АВЛАГА** | 273,350.2 | 292,261.1 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 200.0 | 22,150.0 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 294,725.6 | 369,354.2 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 0.0 | 0.0 |
| **360** | **БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ** | 0.0 | 0.0 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | 2,363,582.6 | 2,475,277.7 |
| **37** | **УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ** | 0.0 | 0.0 |
| **37100** | **Урт хугацаат хадгаламж** | 0.0 | 0.0 |
| **37200** | **Үнэт цаас** | 0.0 | 0.0 |
| **37300** | **Урт хугацаат зээл** | 0.0 | 0.0 |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,363,582.6 | 2,475,277.7 |
| 39100 | Газар | 0.0 | 0.0 |
| **39200** | **Биет хөрөнгө** | 2,279,642.6 | 2,391,445.9 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 83,940.0 | 83,831.8 |
| **39400** | **Бусад хөрөнгө /ТӨҮГ/** | 0.0 | 0.0 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | 3,030,698.9 | 3,366,706.6 |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | 46,906.0 | 14,228.9 |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 46,906.0 | 14,228.9 |
| **41100** | **Богино хугацаат үнэт цаас** | 0.0 | 0.0 |
| **41200** | **Богино хугацаат зээлийн өглөг** | 0.0 | 0.0 |
| **41300** | **Өглөг** | 46,906.0 | 14,228.9 |
| **41400** | **Урьдчилж орсон орлого** | 0.0 | 0.0 |
| **42** | **УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 0.0 | 0.0 |
| **42100** | **Урт хугацаат үнэт цаас** | 0.0 | 0.0 |
| **42200** | **Урт хугацаат зээл** | 0.0 | 0.0 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 2,983,792.9 | 3,352,477.6 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 2,983,792.9 | 3,352,477.6 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,297,412.2 | 1,297,412.2 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 0.0 | 0.0 |
| 51102 | Өмч /хувийн/ /ТӨҮГ/ | 0.0 | 0.0 |
| 51103 | Өмч /хувьцаат/ /ТӨҮГ/ | 0.0 | 0.0 |
| 51104 | Халаасны хувьцаа /ТӨҮГ/ | 0.0 | 0.0 |
| 51105 | Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/ | 0.0 | 0.0 |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 0.0 | 0.0 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,402,716.3 | 1,771,401.0 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 283,664.4 | 283,664.4 |
| 51400 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.0 | 0.0 |
| 51500 | Бодлогын өөрчлөлт алдааны залруулга | 0.0 | 0.0 |
| 51600 | Нөөцийн сан | 0.0 | 0.0 |
| 52 | Хяналтын бус хувь оролцоо | 0.0 | 0.0 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | 3,030,698.9 | 3,366,706.6 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2020оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,028,639.1 | 2,413,590.6 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 64,867.4 | 149,122.4 |
| 110 | Орлогын албан татвар | 39,816.7 | 20,234.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 39,816.7 | 20,234.7 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | 0.0 | 0.0 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 0.0 | 0.0 |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | 0.0 | 0.0 |
| 1104 | Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар | 0.0 | 0.0 |
| 112 | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого | 0.0 | 0.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 630.0 | 33,335.8 |
| 114 | Нэмэгдсэн өртгийн албан татвар | 0.0 | 0.0 |
| 115 | Онцгой албан татвар | 0.0 | 0.0 |
| 116 | Тусгай зориулалтын орлого | 0.0 | 0.0 |
| 117 | Гадаад үйл ажиллагааны орлого | 0.0 | 0.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 24,420.7 | 95,551.9 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 361,312.3 | 289,606.4 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 361,312.3 | 289,606.4 |
| 121 | Хөрөнгийн орлого | 0.0 | 0.0 |
| 122 | Тусламжийн орлого | 0.0 | 0.0 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 0.0 |
| 124 | Зээлийн орлого | 0.0 | 0.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,602,459.5 | 1,974,861.8 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,786,661.2 | 1,962,724.5 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,786,661.2 | 1,962,724.5 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,708,604.8 | 1,841,887.1 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,025,063.5 | 1,054,907.9 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 129,493.7 | 138,000.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 158,392.8 | 151,616.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 56,290.1 | 63,356.1 |
| 2105 | Нормативт зардал | 61,126.0 | 96,056.5 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,946.7 | 19,709.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 9,268.5 | 6,562.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 38,568.2 | 32,230.2 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 224,455.3 | 279,447.5 |
| 211 | ХҮҮ | 0.0 | 0.0 |
| 212 | ТАТААС | 0.0 | 0.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 78,056.4 | 120,837.4 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 0.0 | 0.0 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 241,977.9 | 450,866.1 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 0.0 | 0.0 |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 81,150.7 | 82,181.4 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V) | 160,827.2 | 368,684.7 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | 2020 оны 12-р сарын 31 | 2021 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 1,711,404.1 | 2,141,140.0 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 64,867.4 | 149,122.4 |
| 110 | Орлогын албан татвар | 39,816.7 | 20,234.7 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 39,816.7 | 20,234.7 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | 0.0 | 0.0 |
| 1102 | Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч | 0.0 | 0.0 |
| 1103 | ААН-ын орлогын албан татвар | 0.0 | 0.0 |
| 1104 | Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар | 0.0 | 0.0 |
| 112 | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого | 0.0 | 0.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 630.0 | 33,335.8 |
| 114 | Нэмэгдсэн өртгийн албан татвар | 0.0 | 0.0 |
| 115 | Онцгой албан татвар | 0.0 | 0.0 |
| 116 | Тусгай зориулалтын орлого | 0.0 | 0.0 |
| 117 | Гадаад үйл ажиллагааны орлого | 0.0 | 0.0 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 24,420.7 | 95,551.9 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 13,852.1 | 14,124.5 |
| 1181 | Газрын төлбөр | 10,568.6 | 6,219.1 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 0.0 | 75,208.4 |
| 1183 | Бусад татвар | 0.0 | 0.0 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 42,941.2 | 77,569.1 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 42,941.2 | 77,569.1 |
| 121 | Хөрөнгийн орлого | 0.0 | 0.0 |
| 122 | Тусламжийн орлого | 0.0 | 0.0 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 0.0 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,603,595.5 | 1,914,448.5 |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,567,535.5 | 1,821,404.2 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,567,535.5 | 1,821,404.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,487,928.0 | 1,698,067.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,025,252.7 | 1,056,285.4 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 129,294.0 | 137,425.6 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 118,465.9 | 180,288.7 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 55,482.5 | 52,302.1 |
| 2105 | Нормативт зардал | 43,480.2 | 113,953.4 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 19,570.4 | 48,149.6 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 9,268.5 | 6,512.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 45,717.3 | 38,865.6 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 41,396.5 | 64,285.1 |
| 211 | ХҮҮ | 0.0 | 0.0 |
| 212 | ТАТААС | 0.0 | 0.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 79,607.4 | 123,336.7 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 143,868.6 | 319,735.8 |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV) | 0.0 | 0.0 |

| | | | |
|---|---|---|---|
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | 113,934.9 | 210,912.6 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | 113,934.9 | 210,912.6 |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 113,934.9 | 210,912.6 |
| **2260** | **Гадаад эх үүсвэрээр** | 0.0 | 0.0 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | -113,934.9 | -210,912.6 |
| **VII** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН** | 0.0 | 0.0 |
| **14** | **Бусад эх үүсвэр** | 0.0 | 0.0 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | 0.0 | 0.0 |
| **24** | **ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР** | 0.0 | 0.0 |
| **25** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ** | 0.0 | 0.0 |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)** | 29,933.7 | 108,823.2 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 68,906.8 | 98,840.5 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 98,840.5 | 207,663.7 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|---|
| **1** | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 2,822,965.7 | 0.0 | 2,822,965.7 |
| **2** | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 46.1 | 0.0 | 46.1 |
| **3** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 2,823,011.8 | 0.0 | 2,823,011.8 |
| **4** | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | -46.1 | 0.0 | -46.1 |
| **5** | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 0.0 |
| **6** | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 |
| **7** | Өмчид гарсан өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 |
| **8** | Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 |
| **9** | Тайлант үеийн үр дүн | 160,827.2 | 0.0 | 160,827.2 |
| **10** | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 2,983,792.9 | 0.0 | 2,983,792.9 |
| **11** | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 2,983,792.9 | 0.0 | 2,983,792.9 |
| 12 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 |
| **13** | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 2,983,792.9 | 0.0 | 2,983,792.9 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 15 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 16 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.0 | 0.0 | 0.0 |
| 17 | Өмчид гарсан өөрчлөлт | 0.0 | 0.0 | 0.0 |
| 18 | Зарласан ногдол ашиг | 0.0 | 0.0 | 0.0 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 368,684.7 | 0.0 | 368,684.7 |
| **20** | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 3,352,477.6 | 0.0 | 3,352,477.6 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,053,915.70** | **1,775,068.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,788,011.40** | **1,692,887.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,740,667.40** | **1,645,720.17** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,090,571.80** | **1,055,497.40** |
| 210101 | Үндсэн цалин | 677,147.30 | 676,809.31 |
| 210102 | Нэмэгдэл | 297,222.00 | 281,294.77 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 8,064.00 | 6,618.94 |
| 210104 | Урамшуулал | 67,446.90 | 59,283.61 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 40,691.60 | 31,490.77 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **151,628.50** | **137,248.97** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 106,711.60 | 95,788.68 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,229.80 | 10,639.79 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,983.70 | 8,380.80 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,245.90 | 2,038.85 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,457.50 | 20,400.85 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **182,994.40** | **179,738.66** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 20,333.10 | 18,285.06 |
| 210302 | Түлш, халаалт | 159,079.60 | 158,964.59 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,581.70 | 2,489.01 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **52,009.80** | **51,350.61** |
| 210401 | Бичиг хэрэг | 6,977.90 | 6,974.85 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,120.60 | 18,014.96 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,724.70 | 5,594.32 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,800.10 | 1,526.80 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,244.10 | 1,160.35 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 18,142.40 | 18,079.33 |
| **2105** | **Нормативт зардал** | **64,113.40** | **39,399.77** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 16,203.90 | 15,637.34 |
| 210502 | Хоол, хүнс | 42,966.30 | 19,129.48 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 4,943.20 | 4,632.95 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **97,869.80** | **94,537.15** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 61,100.00 | 58,625.00 |
| 210602 | Тавилга | 13,990.70 | 13,134.00 |
| 210604 | Урсгал засвар | 22,779.10 | 22,778.15 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **6,973.60** | **6,273.50** |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,973.60 | 6,273.50 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **28,166.50** | **25,093.75** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,678.20 | 15,686.42 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,585.40 | 2,556.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,395.20 | 1,386.68 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 227.00 | 224.86 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 88.50 | 88.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,255.00 | 4,255.00 |
| 210807 | Газрын төлбөр | 937.20 | 896.80 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **66,339.60** | **56,580.37** |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 59,042.70 | 49,728.23 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,296.90 | 6,852.14 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **47,344.00** | **47,166.94** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **47,344.00** | **47,166.94** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 9,874.40 | 9,703.34 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 31,099.60 | 31,099.60 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,370.00 | 6,364.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **83,222.40** | **82,181.35** |
| 223001 | Бусад хөрөнгө | 83,222.40 | 82,181.35 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **182,681.90** | **0.00** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 182,681.90 | 0.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,053,915.70** | **1,862,418.06** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **975,814.10** | **927,915.58** |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 975,814.10 | 927,915.58 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **865,983.30** | **872,846.59** |
| 320001 | Орон нутгийн төсвөөс | 782,760.90 | 789,624.19 |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 83,222.40 | 83,222.40 |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **19,236.40** | **15,276.66** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 19,236.40 | 15,276.66 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **192,881.90** | **46,379.23** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 52,500.00 | 44,506.03 |
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 103,799.00 | 1,873.20 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 36,582.90 | 0.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 40,527.44 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.00 | 127,877.04 |

### 4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **208,400.43** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **135,950.53** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **108,628.71** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **787.96** |
| 210101 | Үндсэн цалин | 787.96 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **176.61** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 176.61 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **550.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 550.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **6,515.39** |
| 210401 | Бичиг хэрэг | 224.66 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,740.53 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 60.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 426.20 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 64.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **74,553.66** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 72,853.66 |
| 210502 | Хоол, хүнс | 700.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **2,650.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,650.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **238.50** |
| 210702 | Дотоод албан томилолт | 238.50 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **13,771.87** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,771.87 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **9,384.71** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,650.71 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,734.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **27,321.82** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **26,955.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 26,955.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **366.82** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 3.00 |
| 213305 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт,нэмэлт санхүүжил төвлөрүүлэх шилжүүлэг | 4.33 |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 359.49 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **72,449.90** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **72,449.90** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 72,449.90 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **208,412.45** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **208,412.45** |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 1,923.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 192,056.84 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 14,432.62 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | **12.03** |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 12.03 |

## 3. Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Мөрөн сумын Засаг дарга Ц.Батцоож танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсөвт төвлөрүүлэх орлоготой холбоотой зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 44 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Төсвийн тухай хуульд "төсвийн төвлөрүүлэн захирагч" гэж төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг" гэж тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ гэж заасан байна. Үүнд:

- 15.4.1.төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
- 15.4.2.энэ хуулийн 14.2.8-д заасан тайланг нэгтгэн харьяа төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 онд санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр хяналт хийгээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 2,681.9 сая төгрөгийн 1 хувь буюу 24.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 17.1 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж үзэхэд тайлант онд нийт зардал буурсан тул шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзэж 13.7 сая төгрөгөөр тогтоосон.

### 3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 98.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 207.7 сая төгрөг болж, 108.9 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Касст байгаа бэлэн мөнгө | 0 | 0 | 0 | 0 |
| Банканд байгаа бэлэн мөнгө | 98.8 | 206.8 | 108 | 99.57% |
| Замд яваа мөнгөн хөрөнгө | 0 | 0.2 | 0.2 | 0.10% |
| Бусад төсөл, нөөцийн харилцах | 0 | 0.7 | 0.7 | 0.34% |
| **Дүн** | **98.8** | **207.7** | **108.9** | **100%** |

*Эх сурвалж: Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд 207.7 сая төгрөгийн үлдэгдлээс орон нутгийн тусгай сангийн төрийн сан дахь харилцах дансанд 117.0 сая төгрөг, төсөвт байгууллагын харилцах дансанд 11.6 сая төгрөг, төрийн сан дахь ерөнхий орлогын дансанд 79.1 сая төгрөг байршиж байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Хүүхдийн цэцэрлэг: Мөнгөн хөрөнгийг зарцуулахдаа анхан шатны баримт болох и баримтыг үндэслэлгүй 5.4 сая төгрөгийг зарцуулсанд зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.*

### 3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд эхний болон эцсийн үлдэгдэл байхгүй байна.

### 3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 273.3 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 292.3 сая төгрөг болж, 19.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №.2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 1.0 | 1.1 | 0.1 | 0.38% |
| Дансны авлага /ТӨҮГ/ | 0.8 | 0.8 | 0 | 0.27% |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 0 | 65.5 | 65.5 | 22.41% |
| Татаас, санхүүжилтийн авлага | 0 | 0 | 0 | 0.00% |
| Татвар, НДШ – ийн авлага /ТӨҮГ/ | 0 | 0 | 0 | 0.00% |
| Бусад авлага | 9.7 | 6.9 | -2.8 | 2.36% |
| Зээлийн авлага | 261.8 | 218.0 | -43.8 | 74.58% |
| **Дүн** | **273.3** | **292.3** | **19.0** | **100%** |

*Эх сурвалж: Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд авлага 292.0 сая төгрөгийн үлэгдэлд сум хөгжүүлэх сан болон, жижиг дунд бизнесийг дэмжих сангийн зээлийн авлагын үлдэгдэл 218.0 сая төгрөг буюу 74.6 хувийг, төлбөртэй үйлчилгээний авлага 65.5 сая төгрөг буюу 22.4 хувийг эзэлж байна.

Төлбөртэй үйлчилгээний авлага нь сумын Эрүүл мэндийн төвд ЭМДС-аас олгох ковид-19 цар тахлын санхүүжилтийг дутуу олгосонтой холбоотой үүссэн авлага байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *ЭМТ нь ЭМДС-аас авах 1.3 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсныг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийсэн;*

### 3.5.4 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 0.2 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 22.0 сая төгрөг болж 22.0 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Урьдчилж гарсан зардал | 0.0 | 22.2 | 22.2 |
| Цалингийн урьдчилгаа | 0.2 | 0.0 | -0.2 |
| Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа | 0.0 | 0.0 | 0.0 |
| **Дүн** | **0.2** | **22.2** | **22.0** |

*Эх сурвалж: Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа дансны 22.0 сая төгрөгийн үлдэгдэлд ЕБС-д тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдаж авахаар гэрээ хийж мөнгөн хөрөнгийг урьдчилан шилжүүлсэн боловч ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хөрөнгийг тайлант хугацаанд хүлээж аваагүйгээс үүссэн урьдчилгаа байна.

### 3.5.6 Бараа материал

Бараа материалын эхний үлдэгдэл 294.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 369.4 сая төгрөг болж, 74.7 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Тусгай зориулалттай материал | 0.6 | 5.8 | 5.20 |
| Эм боох материал | 14.2 | 57.6 | 43.40 |
| Бичиг хэргийн материал | 8.1 | 8.4 | 0.30 |
| Аж ахуйн материал | 6.9 | 13.7 | 6.80 |
| Сэлбэг хэрэгсэл | 7.8 | 2.6 | (5.20) |
| Түлш, шатах тослох материал | 7.8 | 7.4 | (0.40) |
| Барилгын засварын материал | 7.5 | 7.9 | 0.40 |
| Хүнсний материал | 3.1 | 6.4 | 3.30 |
| Бусад хангамжийн материал | 230.0 | 250.9 | 20.90 |
| Мал амьтад | 8.7 | 8.7 | - |
| **Дүн** | **294.7** | **369.4** | **74.7** |

*Эх сурвалж: Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдаж авсан 253.7 сая төгрөг, үнэ төлбөргүй хүлээж авсан 48.8 сая төгрөгийн бараа материал нэмэгдэж, 228.0 сая төгрөгийн бараа материал зарцуулжээ. Материаллаг өөрчлөлт гарсан нь эм боох материал, аж ахуйн материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл өссөн байна. Энэ нь ковид-19 цар тахлын үед хэрэглэх материалын нөөц бүрдүүлж ажиллаж байгаатай холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт:*

- *Хүүхдийн цэцэрлэг: Жилийн эцэст аж ахуйн материалаас бусад 4.4 сая төгрөгийн материалын үлдэгдлийг тоолж, тооцоо хийж баталгаажуулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв;*

### 3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 3,138.9 сая, эцсийн үлдэгдэл 3,475.0 сая төгрөг болж, 336.1 сая төгрөгөөр өссөн байна.

*Хүснэгт №5 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт (+), Бууралт (-) |
|---|---|---|---|
| Барилга байгууламж, орон сууц | 2,164.5 | 2,357.3 | 192.8 |
| Тээврийн хэрэгсэл | 142.9 | 212.9 | 70.0 |
| Машин тоног төхөөрөмж | 476.2 | 534.2 | 58.0 |
| Тавилга эд хогшил | 155.9 | 168.5 | 12.6 |
| Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 8.4 | 8.4 | - |
| Номын фонд | | | - |
| Бусад үндсэн хөрөнгө | 106.3 | 109.0 | 2.7 |
| Программ хангамж | 1.8 | 1.8 | - |
| Бусад биет бус хөрөнгө | 82.9 | 82.9 | - |
| **ДҮН** | **3,138.9** | **3,475.0** | **336.1** |

*Эх сурвалж: Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 128.7 сая төгрөг, Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар болон үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 207.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдсэн байна.Тайлант онд үндсэн хөрөнгө хасагдаагүй байна.

### 3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 46.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 14.2 сая төгрөг болж, 32.7 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт №6 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өссөн+ Буурсан - | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Ажилчидтай холбогдсон өглөг | 0.4 | 0.2 | -0.2 | 1.4% |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 29.9 | 1.9 | -28.0 | 13.4% |
| Бусад өглөг | 16.6 | 12.1 | -4.5 | 85.2% |
| **Богино хугацаат өр төлбөр нийт дүн** | **46.9** | **14.2** | **-32.7** | **100%** |

*Эх сурвалж: Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Богино хугацаат өр төлбөрийн 14.4 сая төгрөгийн үлдэгдэлд ЭЭС-ийн 11.9 сая төгрөг, ЭМТ-ийн 1.9 сая төгрөгийн өглөг өндөр хувийг эзэлж байна.

### 3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 2,983.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 3,352.5 сая төгрөг болж, 368.7 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт № 7. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/**

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,297.4 | 1,297.4 | 0.0 | 38.7% |
| Хуримтлагдсан үр дүн | 1,402.7 | 1,771.4 | 368.7 | 52.8% |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 283.7 | 283.7 | 0.0 | 8.5% |
| **Дүн** | **2,983.8** | **3,352.5** | **267.3** | **100.0%** |

*Эх сурвалж: Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 7,835.1 сая төгрөг болж 368.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн нөлөөлжээ.

### 3.5.10 Орлогын данс

Үйл ажиллагааны орлого өмнөх онд 2.681.8 сая төгрөг, тайлант онд 3.253.9 сая төгрөг болж, 572.1 сая төгрөгөөр өссөн байна.

**Хүснэгт № 8. Орлого /сая төгрөг/**

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| ТАТВАРЫН ОРЛОГО | 64.8 | 149.1 | 84.3 | 4.58% |
| Орлогын албан татвар | 39.8 | 20.2 | (19.6) | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Хөрөнгийн албан татвар | 0.6 | 33.3 | 32.7 | |
| Бусад татвар, төлбөр хураамж | 24.4 | 95.6 | 71.2 | |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 361.3 | 289.6 | (71.70) | 8.90% |
| Торгуулийн орлого | 14.1 | 25.6 | 11.50 | |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 346.1 | 260.0 | (86.10) | |
| Бусад орлого | 1.1 | 4.0 | 2.90 | |
| Борлуулалтын орлого /ТӨҮГ/ | | | | |
| Хандив тусламж /дотоод/ | | | | |
| ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,255.7 | 2,815.2 | 559.5 | 86.52% |
| Улсын төвлөрсөн төсвөөс санхүүжих | 937.9 | 975.8 | 37.9 | |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 46.7 | 268.8 | 223.1 | |
| Орон нутгийн төсвөөс санхүүжих | 1,261.2 | 1,555.3 | 294.1 | |
| Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 9.9 | 15.3 | 5.4 | |
| Дүн | 2,681.80 | 3,253.90 | 572.10 | 100.00% |

*Эх сурвалж: Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Үйл ажиллагааны орлого 2,743.2 сая төгрөг болж 572.1 сая төгрөгөөр өсөхөд материаллаг өөрчлөлт гарсан нь татварын орлого, тусламж, санхүүжилтийн орлого өссөн ба татварын бус орлого буурсан байна.

Татварын орлого өссөн нь малд ногдуулах албан татвар, ан амьтны нөөц ашигласны төлбөр, торгуулийн орлого өссөнтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого өссөн нь тайлант онд ЭМДС-аас санхүүжих ковид-19 цар тахлын эмчилгээний зардал ЭМТ-ийн нэмэлт санхүүжилтийн дансанд оржээ.

### 3.5.11 Зардлын данс

Тайлант оны нийт зардал 1,786.7 сая төгрөг болж өмнөх оноос 176.0 сая төгрөгөөр өссөн байна.

***Хүснэгт № 9. Зардал /сая төгрөг/***

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | Өсөлт/+/, бууралт /-/ | Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,708.6** | **1,841.9** | **133.3** | **94%** |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,025.1 | 1,054.9 | 29.8 | |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 129.5 | 138.0 | 8.5 | |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 158.4 | 151.6 | (6.8) | |
| Хангамж, бараа материалын зардал | 56.3 | 63.4 | 7.1 | |
| Нормативт зардал | 61.1 | 96.1 | 35.0 | |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 5.9 | 19.7 | 13.8 | |
| Томилолт, зочны зардал | 9.3 | 6.6 | (2.7) | |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 38.60 | 32.2 | (6.4) | |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 224.4 | 279.4 | 55.0 | |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **78.1** | **120.8** | **42.7** | **6%** |
| Бусад урсгал шилжүүлэг | 25.8 | 72.7 | 46.9 | |
| Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 0.4 | 0.2 | (0.2) | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 51.9 | 47.9 | (4.0) | |
| **Дүн** | **1,786.70** | **1,962.70** | **176.00** | **100.00%** |

*Эх сурвалж: Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Тайлант онд цалин хөлс, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, нормативт зардал, эд хогшил, урсгал засварын зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусад урсгал шилжүүлгийн зардал өссөн бол байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж зэрэг зардлууд буурсан байна. Нийт зардал өсөхөд “ковид-19” цар тахлын дэгдэлтийн нөхцөл байдалтай холбоотой цалин хөлс, шимтгэл, нэг удаагийн тэтгэмж урамшуулал, эм эмнэлгийн хэрэгслийн зардал өссөн нь нөлөөлсөн байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Аудитаар нийт 39.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Үүнд:*

- *МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчин батлагдсан төсвийн хэмжээнд тэвчиж болох зардлаас ЗДТГ 5.9 сая төгрөг, ЕБС 6.4 сая төгрөг, Соёлын төв 9.8 сая төгрөг, Хүүхдийн цэцэрлэг 4.1 сая төгрөг, нийт 26.2 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.*
- *ЕБС-д батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин 2.9 сая төгрөг зарцуулсан зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.*
- *ЕБС -д цалингийн зардлыг 10.0 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийсэн болно.*

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Мөрөн сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 11 дүгээр тогтоолд заасанаар Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч тайлант онд 92.7 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 178.7 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 193 хувиар биелүүлсэн байна.

*Хүснэгт 10.* Төсөвт төвлөрүүлэх орлого /сая төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны орлого | 15.0 | 10.9 | (4.1) | 72.7% |
| Хөрөнгийн орлого | 6.8 | 6.5 | (0.3) | 95.6% |
| Хөрөнгө борлуулсны орлого | - | 2.8 | 2.8 | 0.0% |
| Урлагийн тоглолт, спортын тэмцээний шагнал, наадмын бай шагнал | 0.5 | - | (0.5) | 0.0% |
| Бууны албан татвар | 0.6 | 1.1 | 0.5 | 183.3% |
| Малд ногдуулах албан татвар | - | 32.3 | 32.3 | 0.0% |
| Улсын тэмдэгтийн хураамж | 1.2 | 0.8 | (0.4) | 66.7% |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 8.5 | 7.0 | (1.5) | 82.4% |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 4.3 | 6.3 | 2.0 | 146.5% |
| Газрын төлбөр | 8.0 | 6.2 | (1.8) | 77.5% |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 35.3 | 73.5 | 38.2 | 208.2% |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | - | 1.7 | 1.7 | |
| Торгуулийн орлого | 12.2 | 25.6 | 13.4 | 209.8% |
| Бусад орлого | 0.3 | 4.0 | 3.7 | 1333.3% |
| **Нийт дүн** | **92.7** | **178.7** | **86.0** | **193%** |

*Эх сурвалж: Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан*

Орон нутгийн төсвийн орлогын биелэлт нийт дүнгээрээ 193 хувьтай буюу 86.0 сая төгрөгөөр давуулан биелүүлсэн байна. Орлогыг нэр төрлөөр нь тасарсан болон давсан материаллаг өөрчлөлтийг авч үзвэл:

Төлөвлөгөөнөөс давсан нь:

- Хөрөнгө борлуулсны орлого тайлант онд төлөвлөөгүй ба иргэд хөрөнгө борлуулж 2 хувийн татварыг төвлөрүүлсэн;
- Малд ногдуулах албан татварыг тайлант онд төлөвлөөгүй ба 2021 оны 7 сараас татварын хуульд өөрчлөлт орж, шинээр ногдуулалт хийж эхэлсэн;
- Хог хаягдлын үйлчилгээний хураамж 2.0 сая төгрөгөөр давсан нь 2021 онд ковид-19 цар тахлын үед төрөөс иргэд, ААНБ-дад хөнгөлөлт үзүүлсэн;
- Байгалын нөөц ашигласны төлбөр давж биелсэн нь шонхор агнах зөвшөөрлийн тоо төлөвлөснөөс нэмэгдсэн;
- Торгуулийн орлого давж биелсэн нь замын цагдаагийн торгуулийн орлого орон нутагтаа ордог болсонтой холбоотой байна.

Төлөвлөгөөнөөс тасарсан нь:

- Үйл ажиллагааны орлого ковид-19 цар тахлын хөл хориотой холбоотой хувь хүн болон ААН-үүдийн бизнесийн үйл ажиллагаа зогсонги байдалд орж, орлогын эх үүсвэр буурсан.
- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр хэт өндөр төлөвлөгдсөн
- Газрын төлбөр иргэд, ААНБ-ууд төлөлт дутуу хийсэн, газрын төлбөрийг бүрэн төвлөрүүлж ажиллаагүй байгаатай холбоотой байна.

*Аудитын илрүүлэлт:*

- ***Төсвийн төвлөрүүлэн захирагчид татварын орлого нэр төрлөөрөө тасарсан /үйл ажиллагааны орлого 4.1 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.5 сая төгрөг, газрын төлбөр 1.8 сая төгрөг/ зөрчилд зөвлөмж хүргүүлсэн;***
- ***ЗДТГ-т туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 1.9 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн;***

**Төсвийн төлөвлөлт**

Тус төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төсөлд сумын төсвийн орох орлогыг 36.5 сая төгрөгөөр, аймгийн төсөвт орох орлогыг 60.8 сая төгрөг, нийт 97.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс сумын төсөвт орох орлогыг 56.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж 92.7 сая төгрөгөөр, аймгийн төсөвт орох орлогыг 28.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж 89.5 сая төгрөгөөр, нийт 182.2 сая төгрөгөөр баталсан байна..

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2,053.9 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 1,788.0 сая төгрөгийг урсгал зардалд, 83.2 сая төгрөгийг хөрөнгийн зардалд, 182.7 сая төгрөгийг эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд зарцуулахаар батлагдсан байна.

Нийт зардлын 975.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 866.0 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 19.2 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангийн төсвөөс, 192.9 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлийг авч үзвэл:

- Тусгай зориулалтын шилжүүлгээс 927.9 сая төгрөгийг зарцуулж 47.9 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлсэн.
- Орон нутгийн төсвөөс 840.6 сая төгрөгийг зарцуулж, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 25.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт эргэн төвлөрүүлсэн байна.
- Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 46.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөөг 109.9 сая төгрөгөөр тасалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,775.1 сая төгрөг буюу 86.4 хувьтай байгаа нь урсгал зардал 95.1 сая төгрөг буюу 5.3 хувь, хөрөнгийн зардал 1.0 сая төгрөг буюу 1.2 хувийн хэмнэлттэй зарцуулсан ба эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд хөрөнгө зарцуулаагүй байна.

Урсгал санхүүжилтээс хэмнэгдсэн нийт 73.3 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 192.1 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 14.4 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 1.9 сая төгрөг, нийт 208.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 108.6 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 27.3 сая төгрөг, биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардалд 72.5 сая төгрөгийг зарцуулжээ.

**3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мөрөн сумын ТТЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаанд, бүрэн мэдээлсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой ТШЗ-аас нийт 641.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:*

- *ЭМТ-д шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 371.4 сая төгрөгийн 19 , зарлагын 68.9 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ, худалдан авалтын 88.0 сая төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй тухайн хэсэгт хамааралгүй мэдээлэл оруулж, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй зэрэг нийт 528.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн;*
- *ЕБС-д шилэн дансанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын мөнгөн гүйлгээ 112.9 сая төгрөгөөр мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн;*

даатгалын сангийн төсвөөс, 192.9 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлж, аймгаас 631.7 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлийг авч үзвэл:

- Тусгай зориулалтын шилжүүлгээс 927.9 сая төгрөгийг зарцуулж 47.9 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлжээ.
- Орон нутгийн төсвөөс 782.8 сая төгрөгийг төсвийг бүрэн авч, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 25.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт эргэн төвлөрүүлсэн байна.
- ОНХС-аас нийт 2 төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан 83.2 сая төгрөгийн төсвийг бүрэн авч 82.2 сая төгрөгийг зарцуулж, малын тоо толгойн албан татварын 32.2 сая төгрөгийн орлого орж, 36.8 сая төгрөгийн үлдэлтэй байна.
- Аймгаас авах санхүүгийн дэмжлэгийн 631.7 сая төгрөгийг бүрэн авсан байна.
- Нийгмийн даатгалын сангаас 15.2 сая төгрөгийн санхүүжилт авч, батлагдсан төлөвлөгөөнөөс 4.0 сая төгрөг дутуу орж ирсэн байна.
- Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 46.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, батлагдсан төлөвлөгөө 109.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,775.1 сая төгрөг буюу 86.4 хувьтай байгаа нь урсгал зардал 95.1 сая төгрөг буюу 5.3 хувь, хөрөнгийн зардал 1.0 сая төгрөг буюу 1.2 хувийн хэмнэлттэй зарцуулсан ба эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлд хөрөнгө зарцуулаагүй байна.

Урсгал санхүүжилтээс хэмнэгдсэн нийт 73.3 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

**Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 192.1 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 14.4 сая төгрөг, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив 1.9 сая төгрөг, нийт 208.4 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардалд 108.6 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулалд 27.3 сая төгрөг, биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардалд 72.5 сая төгрөгийг зарцуулжээ.

**3.7 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мөрөн сумын ТТЗ-ийн шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг хугацаанд, бүрэн мэдээлсэн байна.

*Аудитын илрүүлэлт:*

*Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой ТШЗ-аас нийт 641.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:*

- *ЭМТ-д шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 371.4 сая төгрөгийн 19 , зарлагын 68.9 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ,*

*худалдан авалтын 88.0 сая төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй тухайн хэсэгт хамааралгүй мэдээлэл оруулж, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаагүй зэрэг нийт 528.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн;*

- *ЕБС-д шилэн дансанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын мөнгөн гүйлгээ 112.9 сая төгрөгөөр мэдээлээгүй зөрчилд албан шаардлага хүргүүлсэн;*

### 3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 2 зөвлөмж, 2 албан шаардлага өсгөн ба биелэлтийг заасан хугацаанд ирүүлсэн байна.

### 3.9 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитаар нийт 7.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж 1 зөвлөмжийг хүргүүллээ.

*Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга.*

Төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд залруулга хийгдээгүй.

*Төвлөрүүлэн захирагчид хүргүүлсэн акт, албан шаардлага*

Төлбөрийн акт, албан шаардлага хүргүүлээгүй.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа төсвийн байгууллага 6, ОНӨҮГ 1, тусгай сан 4, төрийн сан 1, нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 5 байгууллагад дүгнэлт гаргаж, 5 байгууллага түүврээр хамрагдаж, 2 байгууллага аудитад хамрагдаагүй байна.

Аудитад хамрагдсан харьяа 1 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай”, 4 байгууллагын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 693.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 11.3 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 676.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 9 албан шаардлага хүргүүлж, 5.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмжийг хүргүүлсэн. /Хавсралт-1/

### 3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1.1 Төсөвт төвлөрүүлэх орлоготой холбоотой асуудал

*1.1.1 Илрүүлэлт:*

Татварын орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь авч үзэхэд үйл ажиллагааны орлого 4.1 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.5 сая төгрөг, газрын төлбөр 1.8 сая төгрөгөөр тасарсан байна.

*1.1.2 Эрсдэл:*

Орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлээгүй байх

*1.1.3 Өгсөн зөвлөмж:*

Төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр бүрэн биелүүлж ажиллах

*1.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:*

Хүлээн зөвшөөрөв

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 20-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Хавсралт-1

## 5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо: | Аудитын нэр: | Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2022.03.25 | | | ХЭА-2022/16/НА-СТА-ТТЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Хэнтий аймгийн Мөрөн сумын Төсвийн төвлөүүлэн захирагч | | Сая төгрөгөөр |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | **Төсвийн төвлөрүүлэн захирагч** | | | | |
| 1 | Орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь үзэхэд үйл ажиллагааны орлого 4.1 сая төгрөг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 1.5 сая төгрөг, газрын төлбөр 1.8 сая төгрөгөөр тасарсан байна. | 7.40 | Зөвлөмж өгсөн | Засаг дарга, Ерөнхий нягтлан бодогч | Ц.Батцоож, Д.Эрдэнэцэцэг |
| | **ТТЗ-ийн ДҮН** | **7.4** | | | |
| | **Иргэдийн төлөөлөгчдийн хурал** | | | | |
| **1** | Аудитаар зөрчил илрээгүй | - | | | |
| | **ИТХ-ын ДҮН** | **0.0** | | | |
| | **Засаг даргын тамгын газар** | | | | |
| 1 | Батлагдсан төсвийн хүрээнд тэвчиж болох 5,917.0 мянган төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна. | 5.9 | Албан шаардлага өгсөн | ЗДТГ-ын дарга, Нягтлан бодогч | Н.Намжилноров, С.Энхсүх |
| 2 | Туслах үйл ажиллагааны орлогоос 3,200.0 мянган төгрөгийг төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө батлагдсанаас 1,273.2 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 1,926.8 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. | 1.9 | Албан шаардлага өгсөн | ЗДТГ-ын дарга, Нягтлан бодогч | Н.Намжилноров, С.Энхсүх |
| | **ЗДТГ-ын ДҮН** | **7.8** | | | |
| | **Ерөнхий боловсролын сургууль** | | | | |
| 1 | Цалингийн зардлыг 10.0 сая төгрөгөөр илүү бүртгэснийг залруулав | 10.0 | Санхүүгийн тайланд залруулга хийсэн | Нягтлан бодогч | Ц.Угантуяа |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | Батлагдсан төсвийн эдийн засгийн ангилал зөрчин бага үнэтэй түргэн элэгдэх зүйлээс 2.9 сая төгрөгийн хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэсэн. | 2.9 | Албан шаардлага өгсөн | ЕБС-ийн захирал, Нягтлан бодогч | М.Ариунаа, Ц.Угантуяа |
| 3 | Шилэн дансанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын мөнгөн гүйлгээ 112.9 сая төгрөгөөр мэдээлээгүй. | 112.9 | Албан шаардлага өгсөн | ЕБС-ийн захирал, Нягтлан бодогч | М.Ариунаа, Ц.Угантуяа |
| 4 | Батлагдсан төсвийн хэмжээнд тэвчиж болох 6.4 сая төгрөгийг хэмнэж ажиллаагүй байна. | 6.4 | Албан шаардлага өгсөн | ЕБС-ийн захирал, Нягтлан бодогч | М.Ариунаа, Ц.Угантуяа |
| **ЕБС-ийн ДҮН** | | **132.2** | | | |
| **Хүүхдийн цэцэрлэг** | | | | | |
| 1 | Жилийн эцэст аж ахуйн материалаас бусад 4,374.3 мянган төгрөгийн материалын үлдэгдлийг тоолж, тооцоо хийж баталгаажуулаагүй. | 4.40 | Албан шаардлага өгсөн | Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч | Д.Пүрэвжаргал, Ц.Угантуяа |
| 2 | Батлагдсан төсвийн тэвчиж болох зардлаас 13 ажилтанд 2,000.0 мянган төгрөгийн шагнал урамшуулал, 1767.2 мянган төгрөгийн сургалт, 307.0 мянган төгрөгийн албан томилолт нийт 4,074.2 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна. | 4.10 | Албан шаардлага өгсөн | Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч | Д.Пүрэвжаргал, Ц.Угантуяа |
| 3 | Шалгагдагч байгууллагын төлбөрийн баримтын цахим системд бүртгэгдсэн дүн нягтлан бодох бүртгэлд бүртгэгдсэн дүнгээс 5,468.0 мянган төгрөгөөр дутуу | 5.4 | Зөвлөмж өгсөн | Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч | Д.Пүрэвжаргал, Ц.Угантуяа |
| **Хүүхдийн цэцэрлэг ДҮН** | | **13.9** | | | |
| **Эрүүл мэндийн төв** | | | | | |
| 1 | Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 371.4 сая төгрөгийн 19 , зарлагын 68.9 сая төгрөгийн 6 мөнгөн гүйлгээ, худалдан авалтын 88.0 сая төгрөгийн 3 мэдээллийг байршуулаагүй тухайн хэсэгт хамааралгүй мэдээлэл оруулж, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгсөн боловч зөрчил арилгаагүй зөрчилд 1 албан шаардлага хүргүүлэв. | 528.3 | Албан шаардлага өгсөн | ЭМТ-ийн дарга, нягтлан бодогч | Б.Мягмаржав, Г.Хэрлэн |
| 2 | ЭМДС-аас авах авлагыг 1.3 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсныг санхүүгийн тайланд залруулав. | 1.3 | Санхүүгийн тайланд залруулга хийсэн | Нягтлан бодогч | Г.Хэрлэн |
| **ЭМТ-ийн ДҮН** | | **529.6** | | | |
| **Соёлын төв /Түүвэрт хамрагдсан /** | | | | | |
| 1 | Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй төсвийг хэмнэлт гаргаж ажиллаагүй1970.1 мянган төгрөг, 1.4 дэх заалтыг зөрчиж төсвийн хөрөнгөөр 7800.0 мянган төгрөгийн тавилга худалдаж авсан | 9.8 | Албан шаардлага өгсөн | Соёлын төвийн дарга, нягтлан бодогч | Ц.Цэндбаяр, С.Энхсүх |
| **Соёлын төв ДҮН** | | **9.8** | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| СХС /Түүвэрт хамрагдсан / | | | | | |
| | Ауитаар зөрчил илрээгүй | - | | | |
| ЖДБДС /Түүвэрт хамрагдсан / | | | | | |
| | Ауитаар зөрчил илрээгүй | - | | | |
| ОНХС /Түүвэрт хамрагдсан / | | | | | |
| | Ауитаар зөрчил илрээгүй | - | | | |
| БХС /Түүвэрт хамрагдсан / | | | | | |
| | Ауитаар зөрчил илрээгүй | - | | | |
| **Харьяа байгууллагуудын санхүүгийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийн дүн** | | **693.3** | | | |
| **НИЙТ ДҮН** | | **700.7** | | | |

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 04 дугаар сарын 19 Дугаар 243/A23704119 ХЭА 2022/138/НА-СТА-ТШЗ Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Мөрөн сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зайлшгүй шаардлагатайгаас бусад зардлыг тэвчиж, батлагдсан зардлын дүнд 1,970.1 мянган төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй, төсвийн хөрөнгөөр 7,800.0 мянган төгрөгийн тавилга худалдаж авсан байна.

Энэ нь Монгол улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1 дугаар зүйлийн 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах”, 1.4-д “энэ тогтоол батлагдахаас өмнө /2021.02.17/ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх; гэж заасныг баримталж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д **“**хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал**”** гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Мөрөн сумын Соёлын төвийн дарга Ц.Цэндбаяр, нягтлан бодогч С.Энхсүх нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Х.ЕРКЕГҮЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

Монгол Улс, Чингис хот, 4-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас:99775390